



The Wonder Weeks

Хүүхдийн хөгжлийн хуанли

Хөгжлийн үсрэлт гэж юу вэ?

Та өөрийгөө нэгэн дассан сурсан орчиндоо унтаж байна гээд төсөөлөөд үзээрэй. Нэг өглөө сэрсэн чинь таны мэдэх эргэн тойрны бүх зүйл өөрчлөгдсөн байвал ямар санагдах вэ? Мэдээж таагүй санагдах байх, гайхна, айна, сандарна. Танил хүн харагдвал тэр хүнрүү тэмүүлж ойр байхыг хүснэ, тэр хүнээс холдохыг хүсэхгүй.


Тэгвэл таны хүүхэд хөгжлийн үсрэлт хийх болгондоо ийм мэдрэмжийг авдаг.

1971 оноос хойш хийгдсэн судалгааны үр дүнгээс хүүхэд амьдралынхаа эхний 20 сард яг 10 хөгжлийн үсрэлт хийдгийг баталж чадсан. Тэгээд яг хэзээ болдгийг нь хүртэл тооцоолоод гаргасан. Үсрэлт болгоноор хүүхэд хорвоо ертөнцийг өөрөөр харж эхэлдэг, шинэ ур чадвар сурдаг бөгөөд хөгжиж дэвшиж байдаг. Тэгэхээр яг үсрэлт эхлэхийн өмнө хүүхэд муухай аашилж, учир нь олдохгүй байгаа нь яг үнэндээ маш том эерэг өөрчлөлт болж байгаагийн шинж билээ.

Мөн үсрэлтийн үргэлжлэх хугацаанд нойр нь эрс муудаж, ойр ойр сэрэх, муухай аашлах, хоолондоо муу болох, ээжээсээ эсвэл ааваасаа гэнэт салахгүй болох зэрэг түгээмэл шинж тэмдгүүд илэрдэг.

Үсрэлтийн оргил үе гэж байдаг бөгөөд та дараах хуанли хэсэгт бороотой үүлээр тэмдэглэснийг хараарай. Энэ үед хүүхдийн хамгийн тогтворгүй ааштай, нойр муутай байдаг үе нь байдаг.





Энэ үеэр ааштай байна & уйлагнана



Содон сонин өөрчлөлтгүй байна



Энэ долоо хоног нь оргил ааштай үе



Ааш тогтуун, тайван байна



29, 30 долоо хоногтой/ 7-9 сартай үед аашилж уйлагнах нь яг хөгжлийн үсрэлтийн үе биш бөгөөд ээж нь өөрөөс нь холдох боломжтой юм байна гэж хүүхэд ойлгож эхэлдэг. Энэ ойлголт нь бол маш том оюуны хөгжил, дэвшилт. Орон зайны ойлголттой болж байгаа.



Хөгжлийн аль үе дээр байгааг нь яаж мэдэх вэ?

Хүүхэд яг төрсөн огноо нь энэ хуанлид хамаагүй байдаг бөгөөд яг оновчтой үеийг нь олохын тулд төрөх байсан өдөр нь илүү чухал байдаг "due date". Яагаад гэвэл хүүхдийн тархи, оюуны хөгжил нь төрснөөсөө биш хэвлийд байхаасаа бүрдэж эхэлсэн байдаг.

Заримдаа хүүхэд төрөх өдрөөсөө 3 долоо хоногийн өмнө төрөх тохиолдол байдаг. Мэдээж энэ хүүхэд төрөх өдрөөсөө 2 долоо хоногийн дараа төрсөн хүүхдийн тархины хөгжлөөс тэс ондоо байна. Энэ хөгжлийн үеийн ялгаанууд нь ихрүүд болон дутуу төрсөн хүүхдүүд дээр бас ажиглагддаг.

Төрөх ёстой байсан өдрөөр нь хүүхдийнхээ аль үед явж байгааг мэдэх боломжтой бөгөөд хуанли дээр тэмдэглэсэн хугацаагаас 2 долоо хоногийн наана цаанатай байх бол хэвийн гэж үздэг байх нь.





Үсрэлт 1

4 - 5 долоо хоног (1 - 2 сартай)



МЭДРЭМЖЭЭР ДҮҮРЭН ХОРВОО

Ингээд эхний үсрэлт нэг мэдэхэд л хүрээд ирлээ. Мэдрэмжээр дүүрэн үе. Энэ үсрэлтээр нярайн биеийн бодисын солилцоо, дотоод эрхтнүүд болон 5 мэдрэхүй нь маш хурдтай хөгждөг. Нярай арай хийж хэвлийн гаднах амьдралд дасан зохицож байсан чинь дахиад л бүх зүйл өөрчлөгдлөө.

Үсрэлт 1 : Мэдрэмжээр дүүрэн хорвоо

Бүх мэддэг зүйлс нь, эргэн тойрондоо арай хийж дассан бүхэн нь энэ үсрэлтээр нярайд тэс өөр мэдрэмж авчирдаг. Томчууд бидний хувьд энэ бүхнийг ойлгох хэцүү байдаг яагаад гэвэл бид эргэн тойрны бүх зүйлийг харах өнцөг шал өөр байдаг учир. Та хүүхдээ энэ үсрэлтийн өмнө ба дараа гэх ялгааг амархан харах болно. Гэнэт нэг л өөр болсон юм шиг санагдана.

5 мэдрэхүйн аль нэгэнд нь илүү дуртай байхыг ажиглаж магадгүй мөн арай хол байгаа эд зүйлсийг харж чаддаг болох, эрс тэс өнгөнүүдийг анхааралтай харах гэх мэт зүйлс ажиглагдана.

Дуртай мэдрэхүй

Бүх хүүхдийн 5 мэдрэхүй нь асар хурдтай хөгждөг. Эргэн тойрны орчиндоо юу болж байгаад анхаарал хандуулах нь өдөр өдрөөр ихсэж өөрсдөд нь мэдрэгдэж байгаа тэрхүү мэдрэмжээ илүү анзаарч эхэлдэг. Энэ авч байгаа мэдрэмжээ хүүхэд болгон өөрөөр илэрхийлнэ. Харсан бүхэндээ гайхширдаг хүүхэд ч бий, эсвэл сонин содон дуу чимээнд илүү татагддаг ч хүүхэд бий. Зарим хүүхдүүд өдөржин тэврүүлж энгэрт наалдаж, ямар нэгэн байдлаар хүрэх мэдрэмжээрээ тайвшралт авдаг. Хүүхэд болгон өөр.

Нярайн толгойн тойрог

Энэ үсрэлтээр таны хүүхдийн толгойн хэмжээс эрс томорсон байх нь харагдана. Иймэрхүү гэнэтийн өсөлтийг та дараа дараагийн үсрэлт болгоноос харах болно. Хүүхдийн толгойн тойрог нь аажим аажмаар биш иймэрхүү гэнэт бөгөөд хурдан байдлаар томордог.

Эхний нулимс

Үсрэлт 1-ийг давсны дараа таны хүүхэд нулимстай уйлж эхэлдэг. Дөнгөж төрсөн нярай чанга уйлдаг боловч нулимсгүй байдаг. Мэдээж уйлахад тодорхой хэмжээнд шингэн гардаг боловч нулимс нь урсах хэмжээнд бол биш байдаг байсан байх нь.

Хол байгаа зүйлийг олж харах

Нярай хүүхэд юу харж чаддаг чаддаггүй дээр олон маргаан байдаг. Зарим нь нярай хүүхэд огт өнгө хардаггүй гэдэг, зарим нь бүүр хагас сохор ч байдаг гэдэг. Аль нь ч үнэн биш бөгөөд нярай төрөлхийн нүдний эмгэггүй л бол нүд нь хэвийн л хардаг. Гэхдээ бүх зүйл хэвийн байлаа гээд том хүнийхтэй адилхан харж, тунгааж чаддаг гэсэн үг бол бишээ. 4, 5 долоо хоногтойгоосоо хүүхдийн бүх зүйл нь асар хурдтай хөгжиж эхэлдэг бөгөөд гэнэт эргэн тойрны ойр хавьдаа их анхаарал хандуулах чадвартай болсон байдаг. Дөнгөж төрсөн үедээ 20 - 30 см зайд байгаа зүйлийг л харж чаддаг байсан бол (Мээмээ хөхөж байхдаа ээжийнхээ царайг харах зай) одоо 70 - 80 см хүртэл харж чаддаг.

Эрс тэс өнгөнд татагдах

Хар цагаан эсвэл маш тод ялгарах өнгөнд хүүхэд нь анхаарч эхэлж байгааг та анзаарч байгаа байх. Илүү тод бөгөөд хол харж сурч байгаа учраас энэ үсрэлтийн дараа бүр илүү харж чаддаг болсныг та ажиглах болно. Нарийн ширийн хээ гэхээсээ илүү эрс тэс ялгаатай өнгө эд зүйлс сонирхлыг маш их татна. Жишээ нь энэ зурган дээр та нохойг илүү харах бол хүүхэд хар цагаан хээг л зөвхөн харж анхаарлаа төвлөрүүлнэ.



Дотоод эрхтэн ба бодисын солилцоо

Хоол боловсруулахад тулгарч байсан олон асуудлууд энэ үсрэлтийн үед ихэнх нь зүгээр болсон байдаг. Бодисын солилцоо буюу метаболизм нь асар хурдтай өөрчлөгдөж байгаа. Мөн хүүхэд арай илүү удаан сэрүүн байж эхэлдэг.

Дөнгөж төрсөн нярайн үеийн ур чадваруудаа мартах

Бүх мэдрэхүй нь асар хурдтай хөгжиж байгаа боловч тэр бүх мэдрэмжээ ойлгож шингээж тогтоож чаддаггүй. Төрхдөө хийж чаддаг байсан ур чадвараа мартах нь хэвийн. Жишээ нь тодорхой дэс дараатай (зууван хэлбэрт 3 цэг) хүний нүүрийг нүдээрээ болон толгойгоороо дагуулж харж чадахаа больдог. Дуу чимээ болгонд анхаарлаа хандуулах болон хүний нүүрний хувирлыг дуурайхаа бас больж эхэлдэг.

Үсрэлт 1 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Хэвийн үеэсээ илүү уцаарлах
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Бишүүрхэх
- Өлссөндөө сүү уухаасаа илүү тайвшрах гэж мээм хөхөх, сосог хөхөх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 1 дараа сурсан ур чадварууд

- Эд зүйлсийг илүү удаан анхаарч, дахин дахин харах
- Дуу чимээнд анхааралтай хандаж, сонсож байгаагаа мэдрэх
- Нулимс урсаж эхэлнэ
- Анх удаа инээнэ
- Амьсгал нь арай хэвийн хэмнэлтэй болдог
- Хэхрэх болон хахах, цацах нь арай багасах

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 2

8- 9 долоо хоног (2 сартай)



ДАВТАМЖ ХЭМНЭЛЭЭР ДҮҮРЭН ХОРВОО

2 дох үсрэлт ирлээ. Өмнө эргэн тойрноо бүхэлд нь мэдэрдэг байсан одоо давтамж гэж юм байдгийг анхаарч эхэлдэг. Харах, сонсох, үнэрлэх, хүрэх, амтлах гээд юм болгон давтамжтай хэмнэлтэйг ойлгож эхэлнэ.

Үсрэлт 2 : Давтамж хэмнэлээр дүүрэн хорвоо

Янзан бүрийн давтамж, хээ харж мэдэрч эхэлж байхдаа хүүхэд өөрийнхөө гараа анхаарч эхэлдэг. Гараа яаж хөдөлгөх, гар гэж ийм юм байдгийг ойлгосон байна. Таны нүүрийг бас арай өөрөөр харж байгааг та харах бөгөөд толгойн тойрог нь дахиад эрс томорсон байна. Олон төрлийн шинэ дуу авиа гаргаж, та хүүхэдтэйгээ илүү харилцаж эхэлнэ.

Хээ харах

Судалтай цамц, толботой алчуур гэх мэт дүрсэн хээг төсөөлөөд үзээрэй. Хийсвэр уран зураг (abstract art) нь олон өнгө дүрс хээ холилдсон байдаг. Таны хүүхэд ийм зургийг маш их сонирхож удаан анхаарах болно. Үл мэдэгдэх хээнүүд бас байдаг, жишээ нь модны мөчрүүд, ханан дээр тусах сүүдэр, муур нохойн үсний хээ. Бид нээх тоохоо больсон байдаг ч хүүхдийн хувьд бүгд шинэ учир маш их сонирхолтой байдаг.

Нүүр царайг өөрөөр харах

Таны нүүрийг харах өнцөг ойлголт нь өөрчлөгдөж эхэлнэ. Энэ үсрэлтээс өмнө таны ерөнхий нүүрний тойрог хэлбэрийг нь хардаг байсан бол одоо яг таны нүүрийг ажиглаж эхэлнэ. Яагаад гэвэл таны нүүр тэр чигтээ давтамжтай хээ. Хүүхдийн хүүхэн харааны хөдөлгөөнийг нь ажигласнаар ээж аавынхаа нүүрийг яаж хардгийг нь тодорхойлсон байна.



1

2

3

4

5

Нярайн толгойн тойрог

7 - 9 долоо хоногтойд хүүхдийн толгойн тойрог эрс томордог. Тархины мэдээлэл дамжуулах сувгууд нь бас өөрчлөгдөж эхэлдэг. Инстинкт маягийн хөдөлгөөнүүд нь багасаж, өөр өөрийгөө илүү удирдсан хөдөлгөөн гаргах нь ажиглагдана.

Дуу авиа гаргах

Давтамж хэмнэл хээгээр дүүрэн хорвоод таны хүүхэд эдгээр шинэ зүйлсийг харахаас гадна бас мэдэрч эхэлдэг. Та хоолойгоороо хээ гаргах боломжтойг мэдсэн үү? Хүний хоолойн хайрцаг зарим дуу чимээг яг нэгэн хэмнэлтэй гаргах чадвартай учир таны хүүхэд одооноос богино "аа" "уу" "өө" гэсэн авиаг та нарийн сонсвол хэд хэдэн давтамжтайгаар гаргаад эхэлдэг.

Эхний харилцан яриа

Та хүүхэдтэйгээ одоо харилцах боломжтой. 2 хүн хоорондоо ээлжлэн "ярихтай" ижил байдаг. Таны мэдэхгүй хэлээр нэг хүн яриад байвал та ойлгохгүй шүү дээ, яг тэрэнтэй адил хүүхэд таныг бас ойлгохгүй боловч харилцах бол бүрэн боломжтой байдаг.

Гараа олох, гараа удирдаж сурах

Урд нь байгаа 2 юмаа одоо л гар гэж анзаарч эхэлдэг. Гэнэт урд нь гараад ирсэн юм шиг л гайхна. Эргүүлж холдуулж ойртуулж үзнэ. Энэ үсрэлтээр инстинкт маягийн хөдөлгөөн нь багасаж, хүүхэд чинь нэг л өөр хөдөлж байгаа ажиглагдах болно. Модон хүүхэддэй ч юм шиг, робот шиг нэг хөдөлгөөнөөс нөгөөхрүүгээ хэмнэл давтамжтайгаар шилжиж хөдөлдөг.

Үсрэлт 2 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Хэвийн үеэсээ илүү уцаарлах
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Бишүүрхэх
- Өлссөндөө сүү уухаасаа илүү тайвшрах гэж мээм хөхөх, сосог хөхөх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 2 дараа сурсан ур чадварууд

- Телевиз үзэх дуртай болох, дүрсүүд нь сонирхолтой харагдана
- Нарийн дүрс, холилдсон өнгөнүүд сонирхох
- Толгойгоо өргөж барьж чаддаг болох
- Сонирхол татсан зүйлрүүгээ толгойгоо эргүүлж харах
- Доошоо харж хэвтэхдээ хэвлий толгойгоо өргөх гэж оролдох
- Богино хэмжээний дуу авиа гаргах "аа" "уу" "өө" "ммм"
- Ойр байгаа юмруу гараа чиглүүлэх гэж хичээнэ

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 3

12 долоо хоног (3 сартай)



ЖИГД ШИЛЖИЛТЭЭР ДҮҮРЭН ХОРВОО

Үсрэлт 3 аар эргэн тойронд бүх юмс нэгэн жигд шилжилтээр холбогдодгыг ойлгоно. Харах, сонсох, үнэрлэх, хүрэх, амтлах бас өөрийн бие дээрээ жигдхэн шилжилтүүд болж байгааг ажиглаж эхэлдэг.

Үсрэлт 3 : Жигд шилжилтээр дүүрэн хорвоо

Жигд шилжилт гэдэг нь ямар нэгэн юм бага багаар нэгэн жигд хэмнэлээр өөр зүйл болж хувирахыг хэлнэ. Тэр нь гэрэл тодрох, өнгө хувирах, эсвэл хөдөлж байгаа тоглоом ч байж болно. Бид нар энэ шилжилтүүдийг бүүр анзаарахаа больсон байдаг бол хүүхдийн хувьд ойлгоход маш төвөгтэй хэцүү зүйл байдаг учир үсрэлтийн оргил үе дээрээ шуургатай борооны зургаар хуанли дээр тэмдэглэсэн байдаг. Таны хүүхэд дуу авиа гаргахдаа жигдхэн уянгалуулж дугарч байгааг сонсоорой. Мөн хөдөлгөөний хувьд өмнө робот шиг огцом хөдөлгөөнүүд нь арай жигдэрч эхэлсэн байдаг. Анхны шүлсэн бөмбөлөг үүсгэж үзэх бөгөөд хараа нь нэлээд сайжирна.

Уянгалсан дуу авиа

Яаж дуу авиа гаргаж байгаагаа анзаарна, янзан бүрийн дээд доод хоолойн өнгө холбож эхэлдэг болохоор илүү удаанаар жигд дугарч үзнэ. Жижиг хэмжээний "аа" "уу" биш, олон төрлийн жижиг авиануудаа хооронд нь холбож чанга эсвэл сул, удаан эсвэл богино авианы хооронд жигдхэн шилжиж сурдаг. Эцсийн үр дүнд нь уянгалуулж авиа гаргаж чаддаг болсон байна.

Илүү хөдөлгөөнтэй болж, биеэ удирдах нь сайжирна

Энэ үсрэлтийн дараа таны хүүхэд хөдөлж байгаа юмыг жигдхэн дагаж чаддаг болно. Бас толгойгоо эргүүлэхдээ огцом биш жигд удирдаж сурна. Зөвхөн нүд биш бүх бие нь бүх булчин нь хөдөлгөөнөө мэдэрч өөрийгөө анзаарч эхэлж байгаа. Дотор эрхтэн, булчин, шөрмөснүүд нь хүртэл арай өөрөөр хөгжиж эхэлнэ. Одооноос таны хүүхэд эрс хөдөлгөөнтэй болж, нярайн шинж тэмдэг нь бүр арилсан байна.

Сайн уу шүлсэн бөмбөлгүүдээ

Амных нь эргэн тойронд шүлсэн бөмбөлгүүд ажиглагдана. Амны хөндий болон хэлний булчингууд нь нэгэн жигд хөдөлгөөн хийдэг болсноор шүлсээрээ бөмбөлөг үүсгэж үлээж үзнэ. Юунд дуртай дургүйгээ сайн илэрхийлж байгаа бөгөөд та хүүхэдтэйгээ байнга хариу үйлдлээр харьцаж байгаарай. Олон төрлийн дуу авианд нь бид хариу өгснөөр хоолойн өнгө аяс дуурайж яваандаа хурдан хэлд ороход нь маш нөлөөтэй байдаг.

Илүү сайн хардаг болсон

Хүүхдийн харааны төвшин, зай үргэлж сайжирч байдаг. Одоо бараг том хүнийхтэй нэлээд ойролцоо болсон байгаа. Хөдөлж байгаа зүйлийг сайн дагуулж нэгэн жигд байдлаар тасралтгүй харах боломжтой. Заавал толгойгоо хөдөлгөхгүй зөвхөн нүдээрээ дагуулж харах ч чадвартай болсон. Өөрөөс нь холдож байгаа ойртож байгааг мөн ойлгож эхлэх бөгөөд иймэрхүү хөдөлгөөнүүд нь бас жигд шилжилтийн хэсэг билээ. Нэг өрөөнд болж буй бүх үйл явдлыг ажиглаж эхэлж байгаа гээд боддоо? Гайхалтай шүү.

Үсрэлт 3 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Хэвийн үеэсээ илүү уцаарлах
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Бишүүрхэх
- Сүүгээ ууж байхдаа ямар нэгэн байдлаар танаас зуурах, хүрэлцэхийг хүснэ
- Эрхий хуруугаа хөхөх гэж оролдоно
- Идэвх муутай болох
- Дуу муутай болох

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 3 дараа сурах ур чадварууд

- Толгойгоо эргүүлэхдээ жигд хөдөлнө
- Хөдөлж байгаа зүйлийг нүдээрээ жигдхэн дагаж чадна
- Ээжийнхээ хуруунаас барингаа хэвтээ байдлаас доошоо харж чадна, эсвэл доошоо байдлаас дээшээ харах
- Хүний нүүр, нүд, ам, үс их ажиглана
- Хүн болгонтой өөр өөр харьцана
- Шажигнадаг тоглоом ганц хоёр сэгсэрнэ
- Чангаар орилж сурсан. Хоолойгоо чангаруулж, зөөллөж олон авиа гаргана
- Шүлсэн бөмбөлөг гаргана

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 4

15 - 19 долоо хоног (4 - 5 сартай)



ЦУВРАЛААР ДҮҮРЭН ХОРВОО

Үсрэлт 4 дээр таны хүүхэд хорвоо дэлхий олон үйл явдал цувралаар дүүрэн байдгийг ойлгоно. Энэ бол маш том үсрэлт бөгөөд хамгийн хэцүү үсрэлтүүдийн нэг нь. Өдийг хүртэл зөвхөн нэгэн төрлийн хэмнэл, нэгэн төрлийн жигд хөдөлгөөн байдаг гэж ойлгож ирсэн, харин одоо...

Үсрэлт 4 : Цувралаар дүүрэн хорвоо

Өмнөх үсрэлт дээр олон жигд шилжилтүүд, жигд хөдөлгөөнүүд байдгийг сурсан боловч энэ олон зүйлс нь хоорондоо холбоотой гэж мэддэггүй байсан. Одоо таны хүүхдийн эргэн тойронд харагдах, сонсогдох, мэдрэгдэх, үнэртэх, амтагдах зэрэг олон жигд хэмнэлтэй тус тусдаа байсан зүйлүүд нь хоорондоо нийлээд нэгэн цуврал үйл явдал болж байгааг ойлгож эхэлнэ. Энэ мэдрэмжийг бид ойлгохын тулд ойж байгаа бөмбөг төсөөлөх хэрэгтэй. Бөмбөг дээшээ хөөрлөө (жигд хөдөлгөөн), агаарт хоромхон зуур зогсоно (хэмнэл) тэгээд буцаад бууна (жигд хөдөлгөөн) гэх мэт үргэлжилнэ. Яг энэ хэмнэл, жигд хөдөлгөөний давтамж нь нийлээд цуврал гэнэ. Ойж байгаа бөмбөг бол таны хүүхдийн хувьд маш хачин зүйл байх бөгөөд анх удаа бүх юм хоорондоо холбоотой цуврал үйл явдал болж байна гэдгийг ойлгож эхэлнэ.

Том хүн шиг хардаг болсон

Үсрэлт 1 ээс өмнө хир хол хардаг байсныг нь санаж байна уу? Одоо таны хүүхэд тань шиг бүх зүйлийг хардаг хэмжээнд очжээ. Та хир хол харна яг адилхан хэмжээнд харж чадна, гэхдээ юу харж байгаагаа бол тань шиг ойлгох бол мэдээж болоогүй.

Оновчтой юм барьж чаддаг

Юм барьж авна гэдэг бол цуврал үйл явдал бас мөн. 1 секунд ч хүрэхгүй хугацаанд хүний гар тархинаас мэдээлэл авч, баринь гэсэн зүйлрүүгээ тэмүүлж, тэрийгээ барьдаг (Олон хэмнэл, давтамжууд, булчингуудын жигд хөдөлгөөний цувралаар нүд гарын холбоос үүснэ). Том хүмүүс юу ч бодолгүй энийг хийж чаддаг. Хүүхдийн хувьд нэг юм барьж авахын тулд гарын булчингуудаа тохируулна гэдэг шинэ зүйл бөгөөд энэ үсрэлтээс өмнө энэ чадварыг сурах ямар ч боломжгүй байсан билээ. Таны хүүхэд одоо гараараа юм барихын тулд нэг жигд хөдөлгөөнөөс дараагынхруугаа шилжиж сурсан бөгөөд одоо оновчтой шууд барьж чадна. Хүүхэд бас том хүний амыг их сонирхдог яагаад гэвэл амны тэрүүгээр дүүрэн цуварсан үйл явдал өрнөж байдаг.

Цувралаар харах өнцөг

Гараа даллах нь жигд хөдөлгөөнөөр бүрдсэн цуврал үйлдэл. Энэ үсрэлтээс өмнө таны хүүхэд гараа даллах хөдөлгөөнийг нэг л жигд хөдөлгөөн (хүний гар зүүнээс баруун хөдлөх, дараа нь баруунаас зүүн хөдлөх) гэж хардаг байсан бол одоо гараа даллах гэдгийг цуварсан давтамжтай үйл явдал гэж ойлгосон байна. Гэхдээ яагаад гараа далаад байгаа утга учрыг нь сайн ойлгох бол болоогүй.

Цувралаар сонсох өнцөг

До Ре Ми гэх хөгжмийн нотийн хэмнэлийг бид сонсоод мэднэ. Нэг бүлэг дотор байгаа хөгжмийн нотууд нийлээд нэг цуврал болж болдог. Жишээ нь "маамуу нааш ир" дууны "маамуу нааш ир, манайд 2 уулаа тоглоё" хүртлээ дуулахад нэг цуврал.

Шулганаж ярих

Таны хүүхэд хоорондоо холбоотой богино хэмжээний цуварсан авианууд гаргаж байгааг та сонссон уу? Одоо эгшиг болон гийгүүлэгч холбож шулганаж эхэлнэ. Хоолойн өнгө аясаа янзан бүрийн цуврал хэмнэл гаргаж сурч байгаагийн шинж. Энэ шинэ авиануудаа нийлүүлээд "өгүүлбэр" болгож байгаа гэсэн үг. Том хүмүүс бид байнга цуврал хэлбэрээр ярьж байгаагаа та одоо анзаарахгүй байхын аргагүй боллоо.

Үсрэлт 4 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Хэвийн үеэсээ илүү уцаарлах
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Өмнөхөөсөө илүү толгойг нь түшиж өгөх
- Сүүгээ ууж байхдаа ямар нэгэн байдлаар танаас зуурах, хүрэлцэхийг хүснэ
- Эрхий хуруугаа хөхөх гэж оролдоно
- Идэвх муутай болох
- Дуу муутай болох
- Ааш нь янз бүр болж хувирах

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 4 дараа сурах ур чадварууд

- Толгойгоо чиглүүлж ээжийгээ хайж эхлэх
- Газар тавингуут бүх биеэ хөдөлгөж эхэлнэ
- 2 гараараа юм барих гэж тэмүүлнэ
- Амандаа бүх зүйл хийж хазаж үзнэ
- Унжсан тоглоомоор тоглох гэж оролдоно
- Нэрээ мэддэг болсон
- Тэвчээр нь барагдахаар бухимдах ааш гаргаж эхэлнэ
- Д, Б, Л, М гэх гийгүүлэгч оролцуулж эхэлнэ
- Шулганаж ярих: мама, мооомооо, баба, дада, абба, хадада, тата

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 5

23 - 26 долоо хоног (6 -7 сартай)



ХАРИЛЦАА ХОЛБООСООР ДҮҮРЭН ХОРВОО

Үсрэлт 5 аас юм бүхэн харилцаа холбоотой байдгийг ойлгож эхэлнэ. Хүмүүсийн үйлдэл хоорондоо холбоотой гэдгийг ойлгохоос гадна эд зүйл ч бас хоорондоо дээр, доор, хажууд нь, дотор нь гэх харилцаа байдгийг харна.

Үсрэлт 5 : Харилцаа холбоосоор дүүрэн хорвоо

Орон зай гэдэг нь эд зүйл болон хүмүүсийн хоорондын харилцааны нэг хувилбар мөн. Таны хүүхэд та 2-ын хоорондох зай холдож болдгийг анзаарч эхэлнэ. Яг энэ холдож болдог гэдгийг ойлгохоороо хүүхэд 29 долоо хоног (7 сар) хавьцаа ээжээсээ холдохоор уйлж сандарч эхэлдэг. Энэ үсрэлтээр таны хүүхэд жижиг өдөр тутмын үйл явдлуудыг, нарийн ширийн жижиг зүйлс, болон хариу үйлдэл үзүүлдэг бүх юманд анхаарч эхэлнэ жишээ нь гэрлийн унтраалга.

Эд зүйлийн холбоос

Маш энгийн зүйлүүд харилцаатай байж болно жишээ нь 2 юмны хоорондох зай, 2 юмны ялгаа, бие биенийхээ хажууд байна уу, дээр байна уу, дотор нь байна уу гэх мэт. Харилцаа холбоос гэдгийг ойлгож байгаагийн жишээ бол хүүхэд бүх зүйлийг нэг юмны дотор хийх гэж тоглодог тэгээд эргээд бүгдийг нь гаргадаг.

Богино өгүүлбэр ойлгох

Энэ үсрэлтийн дараа таны хүүхэд үг болон тухай үгний утгыг нь холбож ойлгож эхэлдэг. Нэг үг болон түүнийг дагах үйлдлийг нь бие даан ойлгоно жишээ нь "тэгж болохгүй" "хоолоо идье" "гадаа гарцгаая" гэх мэт. Жич: Дассан сурсан орчиндоо өдөр тутмын хэмнэлд нь хэрэглэгддэг үгнүүдийг л ингэж ойлгож эхэлнэ. Орчин солигдохоор мэддэг үгнүүдээ холбож ойлгож чадахаа больдог. Энэ чадвар нь дараа нь хөгждөг.

Ээжээсээ холдохоос айдаг

Маш том хорвоод өөрийгөө зөвхөн жижиг хэсэг нь юм байна гэж хүүхэд гэнэт мэдэрч эхэлдэг. Ээжийгээ жоохон холдохоор их уйлж магадгүй. Энэ бол хэвийн л үзэгдэл. Орон зай хол ойр болдог гэдэг харилцааг ойлгож эхэлж байгаагийн шинж. Ээжийгээ холдуулахгүйн тулд хүүхэд өөрөө юу ч хийж чадахгүй гэдгээ мэдэж энэндээ сандрах, уйлах хариу үйлдэл үзүүлдэг. Хэчнээн хэцүү байсан ч энэ бол маш том хөгжлийн дэвшилт гэдгийг та байнга санаарай. Иймэрхүү хөгжлийн хэцүү үеүд, хорвоо ертөнцтэйгөө танилцах нь амьдралын нэг хэсэг гэдгийг ойлгохоос л хойш, том болж л байгаа учир энийг даваад л гарах хэрэгтэй.

Нарийн ширийн зүйлс анзаарна

Харилцаа холбоосны үсрэлтийн дараа таны хүүхэд гэнэт жижиг сажиг зүйлс сонирхож юмны нарийн ширийн шинж тэмдгийг нь ажиглана. Жишээ нь хувцасны цахилгаан, шошго, жижиг чимэглэл гэх мэт. Заримдаа тоглоомоосоо илүү шошгод хүүхэд илүү анхаарах талтай байдаг шүү. Энгийн зүйлээс илүү бидний нэг нүдээрээ ч харахгүй зүйлд татагддаг: хаалганы нугас, цүнхний бүс, живхний наалт, гутлын үдээс, шкафын хадаас г.м

Товчлуур дарах

Нэг юм хийвэл янзан бүрийн хариу үйлдэл гардаг гэдгийг ойлгож эхэлнэ. 2 зүйл хоорондоо холбоотой харилцаатай гэдгийг туршиж үзнэ жишээ нь энэ товчлуур дарвал дуу гардаг. Ийм учир хариу үйлдэл үзүүлдэг (дуу гардаг, гэрэл асдаг, хөгжим тоглодог) тоглоомууд одоо л сонирхлыг нь татаж эхэлнэ.

Үсрэлт 5 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Сүүгээ ууж байхдаа ямар нэгэн байдлаар танаас зуурах, хүрэлцэхийг хүснэ
- Эрхий хуруугаа хөхөх гэж оролдоно
- Идэвх муутай болох
- Дуу муутай болох
- Муухай аашлах нь ихсэх
- Шөнө их зүүдэлдэг болох
- Живх болон хувцас солиход эсэргүүцдэг
- Зөөлөн чихмэлүүд илүү сонирхох
- Ичимхий байх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 5 дараа сурах ур чадварууд

- Тоглоом болон бусад эд зүйлсийн нарийн жижиг хэсгүүдийг сонирхох
- Хивс сөхөж доогуур нь харах
- Гутлын үдээсээ татах
- Шүүгээ ухаж бүх юмыг нь гаргах
- Нэг тоглоомыг нөгөөхрүү нь хийх гэж оролдох
- Үйлдэл & үг 2-ыг холбож ойлгох. Анх удаа үйлдэлд нь тохирсон авиа гаргах, жишээ нь юм унангуут "өөө" гэх, эсвэл хүн найтаахаар "чүү" гэх
- Алгаа таших
- 2 тоглоом хооронд нь цохих

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 6

34 - 37 долоо хоног (8 - 9 сартай)



СЭДЭВ АНГИЛЛААР ДҮҮРЭН ХОРВОО

Эргэн тойрны бүх юм өөрийн гэсэн сэдэв, ангилалтай гэдгийг ойлгох Үсрэлт 6. Хүүхэд замдаа тааралдсан юм бүхнийг ажиглаж тунгаан судална. Өөрийнхөө эргэн тойрны жижиг ертөнцөө ойлгохын тулд ангилж байгаагийн илэрхийлэл юм.

Үсрэлт 6 : Сэдэв ангиллаар дүүрэн хорвоо

Юм бүхэн өөрийн гэсэн сэдэв, ангилалтай байдгийг ойлгож эхэлнэ. Жишээ нь "галуу" тэгээд "куак" гэдэг 2 үг хоорондоо хамааралтайг ойлгосноор нэг сэдэв болгодог. Сэдэв үүсгэж хооронд холбоотой бүхнийг ялгаж ангилах, тусад нь ойлгох зүйлс гэж бас байдаг гэх мэт энэ бүхэн хүүхдийн хувьд маш шинэ бөгөөд нэлээд толгой ажилуулсан асуудалтай үе байна. Энэ хөгжлийн үе дээр хүүхдүүд инээдтэй эгдүүтэй алдаанууд их гаргадаг.

Сэдэв ялгаж байхдаа гаргах алдаанууд

Харж байгаа бүхнээ хооронд нь харьцуулах аргаар хүүхэд бүх юмыг ямар нэгэн байдлаар ялгаж ангилж эхэлдэг. 2 зүйл хоорондоо төстэй харагдвал нэг ангилал болгож бодож байгаа нь заримдаа инээдтэй байдаг. Жишээ нь хар цагаан зүстэй үхэр хараад ээж нь энэ "үмбүү" гэж дуугардаг гэж зааж өгвөл дараа нь хүүхэд хар цагаан зүстэй нохой хараад "үмбүү" гэж хэлдэг. Тэгэхээр хүүхэд хар цагаан зүстэй 4 хөлтэй амьтдыг бүгдийг нь нэг сэдэвт ангилсан байна гэсэн үг.

Зарим зүйл хамтдаа байх ёстойг ойлгодог

Энэ үсрэлтийн дараа таны хүүхэд ном дээр байгаа галуу нь зураг гэдгийг, нууран дээр байгаа галуу жинхэнэ бөгөөд "куак" гэж дуугардаг гэдгийг ойлгодог болно. Энэ холбоос нь "галуу" тэгээд "куак" 2 нь хамт нэг сэдэв гэдэг холбоосыг үүсгэсний үр дүн. Галууны зураг, жинхэнэ галуу мөн галуу яаж дуугардаг гэдэг бүхнийг "галуу" сэдэвт сэтгэн бодох чадвартай болсон. Энэ үсрэлтийн үеэр ном дээр хамтдаа үздэг бүхнээ гадаа гарахдаа тайлбарлаж өгвөл хүүхэд маш анхааралтай хүлээж авдаг. Амьтад, цэцэг, машин, савлуур, хүүхдүүд, үүл гээд ярилцаад үзээрэй.

Сэдвүүдийг мэдрэх

Эргэн тойрны зөвхөн харснаараа ангилахаас гадна бусад мэдрэхүйгээ ашиглаж ойлгодог. Юм хир хүнд байна, наалдаж байна уу, гөлгөр байна уу, зөөлөн байна уу гэдгийг сонирхож туршиж байгааг нь анзаараарай. Таны хүүхэд гараа бүх юмруу хийж дүрэх гээд байвал, яагаад гэдгийг нь та одоо мэдэж авлаа.

Тархины өөрчлөлт болон толгойн тойрог

8 сар хавьцаа таны хүүхдийн тархин дахь сахарын хэмжээс нь тархины мэдээлэл дамжуулах процесс нь эрс өөрчлөгддөг. Мөн толгойн тойрог нь бас хурдтай томорсон байдаг.

Үсрэлт 6 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Илүү их сүүгээ уух гээд эсвэл бага уудаг болох
- Байнга өөртөө анхаарал хандуулахыг шаардах
- Гоё ааштай байж байгаад гэнэт муухай аашлах
- Байнга завгүй байлгахыг хүснэ
- Тайван сайхан ааштай болох
- Ердийн үеэсээ илүү яриа байр, шулганах
- Шөнө их зүүдэлдэг болох
- Живх болон хувцас солиход эсэргүүцдэг
- Зөөлөн чихмэл тоглоом тэвэрч тайвшрах
- Улам нялхраад байгаа юм шиг болох

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 6 дараа сурах ур чадварууд

- Ямар нэгэн юм муухай болсон эсвэл заваан болсныг анзаарах
- Хүнийг үйлдлээр нь дуурайдаг
- Толинд өөрийгөө харж сонин царай гаргаж үзэх
- Хүмүүст юу мэдэрч байгаагаа хэтрүүлэн аашилж илэрхийлдэг
- Хаана байна гэж үйлдлээрээ өөр хүүхэдтэй тоглох
- Дуу дуулж өг гэж хэн нэгнээс шаардах
- Ердийн эд зүйлсийн нэрүүдийг ойлгодог: шүдний сойз, хонь, муур, галуу, онгоц
- Гэрээсээ өөр орчинд ээж ааваа таних чадвартай болно

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 7

42 - 46 долоо хоног (11 сар - 1 ой)



ДАРААЛЛААР ДҮҮРЭН ХОРВОО

Үсрэлт 7 дээрээ хүүхэд үйл явдлууд хоорондоо нийлээд дараалал үүсгэдэг гэдгийг ойлгохоос гадна анзаарч, ажиглаж мөн өөрөө туршиж үзнэ.

Үсрэлт 7 : Дарааллаар дүүрэн хорвоо

Олон үйлдлүүд нь тус тусдаа биш нийлэхээрээ дэс дараалалтай байдгийг ойлгодог жишээ нь: хоол идэхэд эхлээд халбагаа барина, халбагаа хоолондоо дүрнэ, хутгаж хоол авна, тэгээд халбагатай хоолоо нүдрүү биш амруугаа хийдэг. Таны хүүхэд нэг үйлдэл хийхийн тулд жижиг тусдаа үйлдлүүдийг хооронд холбож эхэлнэ. Эхэндээ эдгээр үйлдлээ хийхдээ эв хавгүй байдаг ч яваандаа сайжраад ирнэ. Дэс дарааллын өөр нэг жишээ бол хариу үйлдлүүд. Хүүхэд нэг зүйл хийлээ, хэн нэг нь хариу үйлдэл түүнд үзүүлдэг гэдэг дарааллыг ойлгох. Одооноос нэг үйлдэл заавал болж байж нөгөөх нь болдог гэдгийг анзаарч эхэлдэг. Өөрийнхөө юу хүсэж байгааг танд илүү сайн илэрхийлж эхлэх бөгөөд танаас туслалцаа хүсэж олон төрлийн дэс дарааллыг өөрөө туршиж эхэлнэ.

Нэг үйлдлийн дараа нөгөөх нь болдог

Бүх дэс дараалалтай үйлдлүүдэд заавал эхлээд нэг үйлдэл болсны дараа нөгөөх нь болдог гэдгийг ойлгож эхэлнэ. Та хэрвээ анзаарвал бидний амьдрал дэс дарааллаар дүүрэн байдаг. Шүдээ угаах дээр жишээлбэл заавал эхэлж сойзоо гартаа барьж байж шүдээ угаадаг гэх мэт. Усанд ороход эхлээд хувцсаа тайлах хэрэгтэй. Үсээ самнахын тулд эхлээд саамаа гартаа барина.

Юу хүсч байгаагаа илэрхийлэх

Одоо танд юу хүсэж байгаагаа бүрэн илэрхийлэх боломжтой болсон. Үгээр биш гэхэд үйлдлээрээ. Юм идмээр байвал "тэр" гэж заах. Хүүхдийн чинь юу хүсэж байгаагаа илэрхийлэх нь эргээд танаас хариу үйлдэл гардаг нь мөн дараалал билээ. Жишээ нь хаашаа явахаа үгээр биш хуруугаараа зааж таныг чиглүүлэх.

Танаас туслалцаа хүсэх

Ямар нэгэн үйлдэл хийх гээд чадахгүй байвал танаас туслалцаа авч болдог гэдгийг ойлгож эхэлнэ. Энэ бол хариу үйлдлийн нэг хувилбар: танаас туслалцаа хүсвэл та өгнө. Дараалал. Олон янзаар туршиж үзнэ жишээ нь өөрөө хийж чадах ч чадахгүй гэж таны туслалцаа оролцоог хүсэх гэх мэт. Гэхдээ хүүхэд санаатайгаар тэгдэггүй бөгөөд энэ нь Үсрэлт 10 аас эхэлдэг. Ямар нэгэн үйлдлийг бүрэн дуусгах эсвэл гүйцэтгэхийн тулд ингэж аашилдаг учир хүүхдээ муу санаачилж байна гэж бодож болохгүй, харин өөрөө хийж чадах зүйлд нь байнга дундуур нь оролцохоос татгалзаарай.

Үсрэлт 7 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Гоё ааштай байж байгаад гэнэт муухай аашлах
- Гэнэт тайван сайхан ааштай байх
- Өмнөхөөсөө арай бага "ярих"
- Идэвх муутай болох
- Шөнө их зүүдэлдэг болох
- Учир нь олдохгүй зэвүүн болох
- Живх болон хувцас солиход эсэргүүцдэг

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 7 дараа сурах ур чадварууд

- Эвлүүлдэг тоглоомын 3 хэсгийг нь эвлүүлэх
- Утсаар ярих гэж оролдоно
- Тоглоом давтаж дуурайдаг
- Хоол хийж байгааг дуурайх, халбагаар юм хутгах, сэрээгээр тавгаа цохих
- Юмруу зааж нэрийг нь хэлүүлэхийг шаардана
- Амжилт олохгүй ч өөрөө хувцсаа тайлах гэж хичээнэ
- Өшөө хоолоо идэхийн тулд "mmm" гэж хэлэх
- Өөрийгөө хооллох гэж хичээнэ

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 8



51 - 54 долоо хоног (1 ой - 1 ой 2 сар)



ХӨТӨЛБӨРӨӨР ДҮҮРЭН ХОРВОО

Хөтөлбөр гэдэг нь нэг зорилгод хүрэхийн тулд хүн хийдэг олон төрлийн дараалалтай үйлдлүүдийн нийлбэр юм. Үсрэлт 8 дээр хүүхэд анх удаа олон дараалалтай үйлдлүүд нь бүхэлдээ нэг зүйл гэдгийг ойлгож сурдаг.

Үсрэлт 8 : Хөтөлбөрөөр дүүрэн хорвоо

Хөтөлбөр гэдгийг таны хүүхэд яаж ойлгож байгааг төсөөлөөд үзье. Бохир тавгийг тосгуур дотор хийгээд, ус гоожуулаад, саван дусаагаад, тавгаа цэвэрлэж байгааг (бүгд тодорхой дараалалтай, үсрэлт 7 дээр сурсан) бүхэлд нь аяга тавгаа угаах нэг хөтөлбөр гэдгийг ойлгоно. Дэс дарааллаас хөтөлбөр гэдгийг ойлгох арай хэцүү байдаг яагаад гэвэл эцсийн нэг зорилгод хүрэхийн тулд олон янзын дараалал хэрэглэх боломжтой болдог. Хөтөлбөр гэдэг зүйлийг хүүхэд ойлгосноор нэг өдөрт өрнөдөг олон зүйлийг ажиглаж эхэлнэ жишээ нь аяга таваг угаах, ширээгээ засах, хоолоо идэх, хувцсаа өмсөх, байшин барих, утсаар ярих гэх мэт. Энэ бүгд хөтөлбөр юм. Гэхдээ...хөтөлбөр гэдэг зүйлийг ойлгосон боловч өөрөө хийж чадна гэсэн үг биш юм.

Өөрөө хөтөлбөр санаачлах

Таны хүүхэд өдийг хүртэл амьдралд нь болж өрнөсөн бүх хөтөлбөрүүдийг таньж мэдэж эхэлсэн. Мөн эдгээр хөтөлбөр дотор нь нарийвчлан юу юу болдгийг мэддэг учир өөрөө зарим хэсгүүдийг нь санаачилна. Жишээ нь гадуур хувцасаа аваад гадаа гарахыг шаардах. Хүүхэлдэйгээ бариад орлуу зааж, орон дээр тавих. Зарим иймэрхүү санаачлалд нь одоохондоо бид анзаарахгүй өнгөрөөх талтай, хүүхдээ одооноос сайн ажиглаж ойлгосноор иймэрхүү үйлдлүүдийг нь сайн дэмжиж хөгжүүлж байх хэрэгтэй.

Хөтөлбөрт хариу үйлдэл үзүүлэх

Нэг хөтөлбөр дотор олон үйлдэл дараалал байдгийг ойлгосон хүүхэд заримдаа дундаас нь өөрчлөх гэж эсвэл болиулах гэж оролддог. Дараа нь юу болох гэж байгааг сайн мэдсэн байна. Гадуур хувцсыг нь өмсүүлээд эхлэхээр гадаа гарах гэж байна гэж мэдээд шууд тэрэгэндээ авирах гэж оролдох эсвэл угаалгын өрөөнд ус гоожуулаад эхлэхээр усанд орох гэж байна гээд шууд хувцастайгаа усанд орох гэж зүтгэх.

Хөтөлбөрүүд дуйрайж тоглож эхлэх

Аажмаар илрэх чадвар ч гэлээ таны хүүхэд одооноос аливаа бодит хөтөлбөрийг дуурайж эхэлдэг. Жишээ нь хүүхэлдэйгээ хооллох, зам дагуу машинаа явуулах гэх мэт гэхдээ төсөөлөн бодож тоглох чадвар нь арай хөгжөөгүй байгаа. Энэ нь дараагийн үсрэлт дээр ажиглагдаж эхэлнэ. Харин одоо бодит хөтөлбөрүүдийг дуурайж тоглодог.

"Харилцан ярих" гэж оролдох

Жоохон хүүхдүүд ихэвчлэн маш яриа байдаг. Асуулт, сэтгэлийн хөөрлөөр дүүрэн янзан бүрийн үлгэрүүд ярьж өгдөг (үлгэр гэдэг өөрөө хөтөлбөр байдаг). Эдгээр ярьж байгаа юмандаа таныг хариулахыг шаарддаг. Хэрвээ таны хүүхэд их ярих дуртай бол, та юу гээд байгааг нь сайн ойлгохгүй ч анхааралтай сонсож хариулахыг хичээгээрэй. Сайн сонсож ажиглавал яг юу гээд байгааг нь гадарлах боломжтой байдаг шүү.

Үсрэлт 8 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Гоё ааштай байж байгаад гэнэт муухай аашлах
- Зүгээр сууж байж чадахгүй болох
- Гэнэт тайван сайхан ааштай байх
- Дүрсгүйтэж эхлэх
- Муухай аашилж уцаарлах үеүд нь ихсэх
- Атаархаж эхлэх
- Бишүүрхэх
- Шөнө их зүүдэлдэг болох
- Нялхраад эхлэх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 8 дараа сурах ур чадварууд

- Гадуур хувцсаа авчирж өгөх
- Өөрөө хувцсаа гаргаж ирээд өмсөх гэж оролдох
- Зөв шүүгээнд нь тоглоом эсвэл өөр эд зүйлсийг буцааж тавьдаг
- Цаасан дээр юм сараачиж үзнэ
- Хүүхэлдэйгээ усанд оруулах гэж оролдоно
- Нуусан юмыг олж чадна
- Бусад гэр бүлийн гишүүд юу хийж байгааг сайн ажиглана
- Утас эсвэл таблет дээр байгаа дуртай апп-аа олж чадна

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.

Үсрэлт 9



60 - 64 долоо хоног (1 ой 3 сар - 1 ой 4 сар)



АРГАЧЛАЛААР ДҮҮРЭН ХОРВОО

Ямар нэгэн зорилго биелүүлэхийн тулд хэрэглэх олон аргууд байдгийг ойлгож хүүхэд янз бүрээр туршиж эхэлнэ. Үсрэлт 9 дээр хүүхэд хорвоо ертөнц ийм ийм зарчимтай юм байна гэдгийг бас ойлгоно.

Үсрэлт 9 : Аргачлалаар дүүрэн хорвоо

Олон төрлийн аргууд хэрэглэж болдгийг ойлгодог. Би энийг болгоомжтой хийх үү? Эсвэл хүчээр хийх үү? Эвээр үзэх үү? Туслалцаа хүсэх үү? гэх мэт аргачлалуудын хувилбарууд бодож эхэлнэ. Өөрөөр хэлбэл ямар нэгэн зорилгодоо яаж хүрэх вэ? гэж бодож байгаа. Хүүхдээ олон төрлийн аргуудыг туршиж үзэх боломжийг нь олгоорой мөн хүүхдэд одооноос юм бүхэнд энгийн хэдэн дүрэм журам байдаг гэдгийг ойлгуулах нь чухал.

Хөтөлбөрийн тухай үсрэлтээсээ ургуулаад...

Үсрэлт 8-ийн хөтөлбөр гэдэг зүйлийг сайн ойлгосон учир тухайн нэг үйлдлийг хийхийн тулд хамгийн тохиромжтой аргыг нь олох гэж олон янзаар туршилт хийж эхэлдэг. Биеэрээ юу юу хийх боломжтойг туршиж үзнэ. Шатаар яаж гарах вэ? Шатаар яаж буух вэ? Таны хүүхэд арай илүү хөдөлгөөний эвсэлтэй болно. Ямарваа нэгэн зорилгод хүрэхийн тулд энэ нь хамгийн тохиромжтой хувилбар юм байна гэж олон янзаар туршсаны эцэст олж сурна.

Хөтөлбөрөө хувиргах

Өмнөх үсрэлт дээр таны хүүхэд нэг хөтөлбөрөөр явахад ижил аргаар ижил дэс дарааллаар ойлгож авсан. Өөр аргаар хийж чадахгүй бас хийхийг ч хүсэхгүй байсан. Харин энэ үсрэлтийн дараа нэг зорилгодоо хүрэхийн тулд олон арга байж болдгийг бас дэс дарааллыг нь хооронд нь сольж болдгийг ойлгосон байна. Мөн хөтөлбөрийн зарим хэсгүүдийг өөрчилж болохгүй юм байна, заавал нэг нь эхэлж болох хэрэгтэй гэдгийг ойлгоно. Үсээ самнах, гараа угаах болон ширээгээ засах гэсэн үйлдлүүдийн дэс дарааллыг сайн ойлгож авдаг. Гэхдээ ойлгох нэг харин өөрөө хийж чадах хоёр шал өөр шүү.

Өдөр тутмын хөтөлбөр

Энэ үсрэлтээр нэг хөтөлбөр олон янзын аргаар хийгдэх боломжтойг ойлгох боловч тэр олон аргууд нь харин хэмжээ хязгаартай байдаг гэдгийг ойлгоогүй байна. Жишээ нь гурвалжин блок тоглоомыг өрөөд тавьсан блокуудын голд нь тавина, блокуудыг олон янзаар өрж болно гэдгийг ойлгосон боловч гурвалжин хэлбэртэй нь зөвхөн хамгийн дээр нь тавих боломжтой байдаг шүү дээ. Зузаан цамцыг нимгэн цамц дээр л өмсдөг, эсрэгээрээ багтахгүй. Харин хувцсаа өмсөх дарааллын дунд оймсыг бол хэзээ нь ч хамаагүй өмсөх боломжтой гэдгийг сурдаг. Энэ насны хүүхдүүд өөрийгөө бүрэн хувцаслах болоогүй ч жижиг сажиг үйлдлүүдийг хийх чадвартай бөгөөд алдаанаасаа байнга суралцаж байдаг. Хүүхэд өөрөө хийж туршиж үзэхээс нааш үйлдлүүдийг ямар аргачлалаар хийж болох болохгүй ойлгож авдаг. Өөрт нь сурах боломжийг нь олгох хэрэгтэй. Хэрвээ та өмнөөс нь бүх зүйлийг нь хийж өгөөд байвал таны хүүхдийн сурах ойлгох яваандаа өөрөө хийж чадах нь хойшлоод л байна гэсэн үг. Гүцнээс аягаруу ус хийж уудаг гэдэг жижиг тоглоом тоглож байгаа хүүхэд ээжийгээ гүцрүү ус хийж байхыг харна. Усыг бол ууна гэдгийг мэдэж байгаа учир шууд гүцнээс нь усыг уух гэж оролдоно, харин ээж нь болиулж аягаруу нь усыг нь хийж өгөөд одоо эндээс уу гэхэд хүүхэд аягнаас уух боловч эргээд гүцнээс нь үлдсэн усыг уух гэж дайрна. Гүцнээс усыг уухад мэдээж илүү хэцүү төвөгтэй байна. Аягаруу хийх дарааллыг нь алгасахгүй байх хэрэгтэй, аяганаас уудаг гэдгийг хүүхэд өөрөө гүцнээс ууж үзэж бүтэлгүйтэхээс нааш ойлгож чаддаггүй.

Хэмжээ хязгаар тавих

Хүүхэд томрох тусам олон янзын муухай ааш, ууртай уцаарлах үеүд гардаг. Энэ насны хүүхдүүд заримдаа яг учир нь олдохгүй өсвөр насны хүүхдүүд шиг аашилдаг. Гэхдээ яагаад? Муухай аашилж уцаарлаж бухимдаж байгаа нь ямарваа нэгэн дүрэм журам шаардлагатай байгаагийн шинж байдаг. Таны хүүхэд юмны дүрэм журмыг сурмаар байдаг гэхдээ сурахын тулд юмны дээд хэмжээ цаад хязгаарт нь заавал хүрж үздэг. Жишээ нь таны тэвчээрийн хязгаар хаана алдагдаж байгааг байж болно. Нийгмийн зөв харилцаатай том хүн өөрийнхөө юу хүсэж байгаагаа заавал бусад хүмүүсийн орон зай хязгаарт нь халдах шаардлагагүйгээр зорилгодоо хүрч чаддаг. Харин таны хүүхэд юу хүсэж байгаагаа мэдэх боловч....

...бусад хүмүүсийн хэмжээ хязгаарт нь тулж байж эндээс хэтэрч болохгүй юм байна гэж мэдэж авдаг. Одооноос юмны хэмжээ хязгаар гэж байдаг гэдгийг заавал заах хэрэгтэй, хэрвээ бүх юманд ямар ч хязгаар байхгүй бол ямар ч дүрэм журам байхгүй гэсэн үг. Аргачлалаар дүүрэн энэ хорвоод юмны хэмжээ хязгаарыг тэр дундаа нийгмийн харилцаан дээр болно болохгүйг мэдэх нь маш чухал.

Эелдэг, найрсаг харьцаа

Аливаа юманд эсэргүүцэл үзүүлэх, зөрүүдлэх, зогсолтгүй нэг юм нэхэх, муухай аашлах, өөрийгөө тусдаа хүсэл эрмэлзэлтэй хүн гэдгээ ойлгох зэрэг энэ бүхэн таны хүүхэд том болж байгаагийн нэг том хэсэг. Хүссэн юмаа авахын тулд заавал муухай аашлахын оронд өөр олон арга хэрэглэж болдгийг одоо ойлгох ухамсартай болсон. Маш сайхан аашилж инээж долигонох, хошигнох зэрэг ааш гаргаж сурна мөн нэг зүйл хийхийн тулд эвийг нь олж болгоомжтой байхыг сурдаг. Зорилгодоо хүрэхийн тулд эерэг харьцаа ашиглаж сурна гэдэг нь маш том хөгжлийн дэвшилт. Хүүхэд үнэхээр ухаантай шүү.

Үсрэлт 9 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Гоё ааштай байж байгаад гэнэт муухай аашлах
- Зүгээр сууж байж чадахгүй болох
- Гэнэт тайван сайхан ааштай байх
- Дүрсгүйтэж эхлэх
- Муухай аашилж уцаарлах үеүд нь ихсэх
- Атаархаж эхлэх
- Бишүүрхэх
- Шөнө их зүүдэлдэг болох
- Нялхраад эхлэх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 9 дараа сурах ур чадварууд

- Тоглоомоо нууж олж тоглоно
- Сонголт хийж эхэлнэ
- Хүссэн зүйлээ авахын тулд дүрсгүйтнэ
- Илүү их зөрүүдлэх
- Өөрөө хоолоо идэж юмаа уухдаа илүү эвсэлтэй болох
- Тоглоомууд өрж тоглохдоо илүү өндөр бас тогтвортой өрнө
- Тэр хаана байна гэж асуухад зааж хариулна
- Хүний хэлж байгааг сайн ойлгох
- Уурлаж уцаарлах аргаар хүссэн зүйлээ авна

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.



Үсрэлт 10



71- 75 долоо хоног (1 ой 5 сар - 1 ой 6 сар)



ТОГТОЛЦООГООР ДҮҮРЭН ХОРВОО

Тогтолцоо гэдэг нь нэг том зүйл нь дотроо олон жижиг тусдаа хэсгээс бүрдсэн ч нийлээд нэг үйлдэл илэрхийлдэг зохион байгуулалт юм. Үсрэлт 10 дээр хүүхэд юм бүхэн өөрийн гэсэн нэгдсэн тогтолцоотой гэдгийг ойлгож эхэлнэ.

Үсрэлт 10 : Тогтолцоогоор дүүрэн хорвоо

Бидний амьдардаг байшин өөрөө тогтолцоотой зүйл байдаг. Олон өрөөнүүд нь хоорондоо уялдаа холбоотойгоор хамтдаа нийлээд нэг байшин, нэг гэр үүсгэдэг. Бодит зүйлээс гадна хүний гэр бүл, нийгэм, ёс заншил, хууль гэх мэт зүйлүүд бас нэгдсэн тогтолцоотой байна. Эдгээр зүйлүүд нь барьцгүй, яг тэр энэ гэж хэлэхээргүй дотроо олон аргачлал, зохион байгуулалттай байдаг. Зарим албан тушаалд тодорхой бичигдээгүй ч нэгдсэн ойлголттой дүрэм журам байдаг, нийгмийн харилцаан дээр мөн адил хүн болгоны мэддэг болно болохгүй харьцаа гэж байдаг.

Энэ бүхэн мэдээж том хүний амьдралын жишээ. Харин таны хүүхэд нийгмийн тогтолцоо, ёс заншил, хууль гэх мэт зүйлүүдийн утга учрыг нь бүрэн ойлгох гэж өшөө хэдэн жил хэрэгтэй. Хүүхэд хамгийн энгийн зүйлээс эхэлдэг бөгөөд дассан сурсан мэддэгтээ ойр байхыг хичээнэ. Өөрийгөө тусдаа хүн тусдаа нэг зохион байгуулалт гэж ухаарч эхэлнэ, мөн ээж аавтайгаа нийлээд нэг гэр бүл болдог гэдэг ойлголт үүсгэнэ. Мөн өөрийнх нь гэр бүл нь хажуу айлын эсвэл өөр хүүхдийн гэр бүлээс өөр гэдгийг анзаарна. Энэ үсрэлтийн дараа эргэн тойрны орон зайгаа сайн мэдэж судалсан байдаг. Өмнөх шигээ нэг зүйлийн олон аргуудыг нь толгойгоо ажиллуулж ойлгох шаардлагагүй болдог бөгөөд тухайн нөхцөл байдалд яаж хувирч ямар аргуудыг хэрэглэх хэрэгтэй гэдгийг шууд мэддэг болно. Тухайн үедээ ямар зан ааш гаргах хэрэгтэй байна гэдгээ ойлгосон байна: уурлах уу, инээх үү, аргадах уу, тэвчээртэй байх гэх мэт. Мөн албаар яг эсрэгээр нь зөрүүдэлж аашлах тохиолдол ч байна. Энэ насан дээрээ бага багаар өөрийнхөө дотоод сэтгэл санааг ойлгож эхлэх бөгөөд, юунд дуртай дургүй өөрийн баримталдаг зарчим үүсгэж эхэлнэ. Үсрэлт 10 нь хүүхдийн өөрийгөө ойлгох, өөрийн хүсэл эрмэлзэлтэй мөн жижиг хэмжээгээр худлаа ярих зэрэг оюун ухааны том үсрэлт байдаг.

Өөрийгөө ойлгох, хүсэл эрмэлзэл, худлаа ярих

Өдөр тутмын амьдралд нь юу болдог тогтолцоог таны хүүхэд одоо бүрэн ойлгосон байна. Өөрөө тусдаа хүн гэдгээ мэдэрнэ. Хүн өөрөө бүхэлдээ нэг том зохион байгуулалт шүү дээ. Тогтолцоогоор дүүрэн хорвоо нь хүүхдийн хувьд томроод ирэхээр өөрийгөө энэ дунд хэн болох гэдгээ ойлгож эхэлдэг. Мөн энэ ойлголт нь бас олон үр дагавартай. Үйлдлээ өөрөө удирдаж юу хийж чадах, юмыг яаж өөрчлөх, өөрөө бие даан шийдвэр гаргах боломжтой гэдгээ мэдсэнээр хүүхэд зөвхөн би, би, би гэсэн үзэлтэй болж эхэлдэг.

Өөрийн гэсэн үзэл бодолтой болсноор бусад хүмүүс ч мөн адил өөрсдийн гэсэн үзэл бодолтойг мэдэж эхэлнэ. Жишээ нь хүүхдээ алив үнсье гэвэл шууд очиж үнсүүлэхгүй байх магадлал өндөр яагаад гэвэл өөрөө энийг шийдэх боломжтойгоо мэдсэн учир. Үүнээс гадна хүүхэд одооноос жоохон худлаа хэлж эхэлдэг. Амандаа их хэмжээний шоколад чихсэн хирнээ таныг шоколад идсэн үү гэхэд үгүй гэж толгойгоо сэгсрэх.


Булчингийн хөгжил сайжрах

Хүний бие бол өөрөө нэгдсэн тогтолцоо. Биеийн бүх хэсгүүд болох булчин, шөрмөс, арьс, судас, дотоод эрхтэн, өөх тос гэх мэт бүгд тус тусдаа тогтолцоотой ч хоорондоо уялдаа холбоотой. Энэ үсрэлтээс өмнө таны хүүхэд биеэ бүхэлд нь нэгдсэн маягаар удирдаж байсан бол одоо арай өөр аргаар биеэ авч явж байгааг нь анзаараарай. Хөдөлгөөн нь арай эвсэлтэй болж, арай тогтвор тэнцвэртэй болсон байдаг.

Ирмэг, өнцөг, хээ


Газар байгаа олон янзын хээ, юмны ирмэг, өнцгөөр дагаж алхах дуртай болдог. 2 замын хооронд цуурсан эсвэл хагархай байвал яг тэр дээр нь алхах гэж оролдоно. Явган хүний замын ирмэгээр нь гарч буух хүүхдийн хувьд хэцүү байдаг ч өөрт нь туршиж үзэх боломжийг нь олгоорой. Тэнцвэртэй байх хэрэгтэй гэдгийг ойлгох болно. Бүх хүүхдүүд иймэрхүү зүйл сонирхохгүй боловч сонирхоод ирэхээрээ их аажмаар эхэлдэг. Та хүүхдээ юмны ирмэг, өнцөг, юмны хээтэй хэсгийг нь анзаарах, дээгүүр нь явж туршиж үзэхийг нь дэмжээрэй. Ямар хөгжилтэй байж болохыг хүүхэд ойлгож эхэлнэ.

...ирэх жилүүдэд мөн хүүхэд эдгээр зүйлд татагдаж очиж авирах, дээр нь гишгэж үздэг хэвээр байна. Та ч гэсэн өмнө нээх тоодоггүй байсан энэ бүхнийг анзаарч эхэлдэг болно. Энд тэнд олон янзын ирмэг өнцөг байдаг, хээ байдаг юм байна гэдгийг та олж хараарай.



Миний эргэн тойрон бол нэг тогтолцоо

Одоог хүртэл нэг гудамж хажуугийн гудамжтай нийлдэг гэдгийг холбож ойлгож чадахгүй байсан харин энэ үсрэлтийн дараа гудамжнууд хоорондоо холбоотой байдаг гэдгийг ойлгоно. Энэ газрын зураг дээр харвал замууд нь хоорондоо нийлээд нэг тогтолцоо үүсгэж байгааг хараарай. Иймэрхүү зохион байгуулалтыг хүүхэд ойлгосон байдаг учир хаашаа явмаар байгаагаа заах, мөн энэ гудамжаар явуул тийшээ очдог гэдгийг мэддэг. Хүсээгүй зүгт нь явуул дургүйцлээ шууд л илэрхийлнэ.



Өөрийн ухамсартай болж эхлэх

Дүрэм журмыг ойлгохын тулд таны хүүхэд ямар нэгэн тогтолцоог нь тодорхойлох гэж хичээдэг болно. Хүүхэд юу болно болохгүйг мэдэх дуртай байдаг учир бүх юмны хэмжээ хязгаарыг нь туршиж үзнэ. Тиймээс аливаа зүйлд ийм дүрэмтэй ийм журамтай гэж зааж өгвөл их таатай хүлээж авдаг. Өөрийнхөө дотоод ухамсар дотоод сэтгэл бодлоо мөн таны өгсөн хариу үйлдлээс бүрдүүлж байдаг. Ингэвэл сайн ингэвэл муу гэдгийг нь сайн зааж өгөөрэй. Хүүхдэд байнга давтамжтай тууштай зааж өгвөл илүү хурдан тогтоож авдаг, гэхдээ тодорхой хэмжээний хугацаа заавал шаарддаг.

Нэгдсэн дүрэм, баримталдаг зарчим

Гэр бүлийн тогтолцоонд олон төрлийн үнэ цэнэ, дүрэм, зохион байгуулалт байдаг. Жишээ нь "байгаа бүхнээ хоорондоо хуваалцдаг" эсвэл "муухай үг хэлж болохгүй" гэх гэр бүлийн бичигдээгүй хирнээ хүн бүхэн баримталдаг зарчим гэж бий. Энэ бүх зарчмыг хүүхэд өөрөө хийж байж л ойлгож авна. Заримдаа хүүхэд өөрийн мэдэлгүй нэгдсэн тогтолцоог ойлгочихсон байдаг. Жишээ нь улаан цүнх бол ээжийнх, хар цүнх бол аавынх гэдгийг ойлгох. Ямар эд зүйлс хэнийх гэдгийг мэднэ. Бүх тоглоом өөрийнх нь биш, заримдаа өөр хүүхэд тоглож дуусахыг хүлээх хэрэгтэйг ойлгож эхэлнэ.

Гэхдээ ойлгох нэг өөр, хүлээн зөвшөөрөх бол шал өөр асуудал. Авмаар байгаа зүйл байсан ч болохгүй гэдэг асуудал тулгарна. Энэ шинэ ойлголт нь хүүхдийг бухимдуулдаг ч бас хөөрхөн үйлдлүүд гаргаж эхэлнэ. Жишээ нь хүнд юм авчирж өгөх дуртай болно. Өөр хүн ямар нэгэн зүйл авмаар байгааг бас ойлгож эхэлнэ. Энэхүү зурган дээр хүүхэд эргэн тойрны орчингоо яаж хүлээж авж байгааг нь хараарай. Өөрийнх нь юм мөн байна биш байна гэдгийг ялгаж эхэлнэ.



Үсрэлт 10 болж байгаагийн шинж тэмдэг



- Илүү их уйлах
- Ээжээсээ салахгүй болох
- Муу унтаж эхлэх
- Гоё ааштай байж байгаад гэнэт муухай аашлах
- Зүгээр сууж байж чадахгүй болох
- Гэнэт тайван сайхан ааштай байх
- Дүрсгүйтэж эхлэх
- Муухай аашилж уцаарлах үеүд нь ихсэх
- Атаархаж эхлэх
- Бишүүрхэх
- Шөнө их зүүдэлдэг болох
- Нялхраад эхлэх

Жич: Дээрх бүгд нэгэн зэрэг болох албагүй

Үсрэлт 10 дараа сурах ур чадварууд

- Болохгүй юм хийж байгаад баригдвал сандардаг
- "Би" гэдэг ойлголттой болно
- Нуугдаад олуулахыг хүснэ
- Жижиг хорхой шавж сонирхоно: шоргоолж, зөгий, ялаа
- Дэлгүүр явах зам зааж чаддаг
- Хувцас ялгахад хэн хэнийх гэдгийг мэднэ
- Жижиг эвлүүлдэг тоглоом хийж чадна. 7, 12, дээд талдаа 20 ширхэгтэйг
- Амлалт өгсөн бол тэрийг өдөржин сануулна. "Жоохон байж байгаад гадаа гарнаа хоёулаа" гэсэн бол байнга гадаа гарахыг шаардах
- Олон үг хэлдэг болно

Жич: Үсрэлт болсны дараа дээрх бүгдийг хийж сурсан байх албагүй бөгөөд нэг нэгээрээ үсрэлтийн дараа аажмаар илэрдэг. Хүүхэд болгон өөр өөр хугацаагаар илэрхийлдэг.